

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД, ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 39/11

Улаанбаатар хот

Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 18.4, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 41/20 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүгчид нэр дэвшигчийн эрүүл мэндийн тодорхойлолт гаргах журам”-ын 2.5 дахь хэсэг, 2.5.1, 2.5.2 дахь заалтад дараах өөрчлөлтийг оруулсугай.

2. 2.5. “Нэр дэвшигчийн сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлтийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дараах ажиллагаагаар гаргана” 2.5.1 “Сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлтийг сэтгэцийн мэргэжлийн зэрэг цолтой, ажлын туршлагатай 3 ба түүнээс дээш эмчийн бүрэлдэхүүнтэй комисс гаргана” гэснийг нэгтгэн 2.5 Нэр дэвшигчийн сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлтийг нийслэлд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд сэтгэцийн мэргэжлийн зэрэг цолтой 3 ба түүнээс дээш эмч, орон нутагт Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэгт сэтгэцийн мэргэжлийн эмчийн хүртээмжээс шалтгаалж ажлын туршлагатай сэтгэцийн эмч, мэдрэлийн эмч, сэтгэл зүйч мэргэжлийн 3 ба түүнээс дээш эмнэлгийн мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй комисс гаргана гэж өөрчлөх

3. 2.5.2. “Сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт гаргах комиссыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын тушаалаар томилно” гэснийг 2.6 “Сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт гаргах комиссыг нийслэлд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал, орон нутагт Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлгийн захирал, даргын тушаалаар тус тус томилно” гэж өөрчлөх

4. Журмын холбогдох заалтыг өөрчлөн найруулсантай холбогдуулан 2.5.3 дахь заалтыг 2.7, 2.6 дахь заалтыг 2.8, 2.7 дахь заалтыг 2.9, 2.8 дахь заалтыг 2.10, 2.9 дэх заалтыг 2.11 гэж өөрчлөх

D:\barimt\tushaal

5. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн мэргэшлийн хорооны ажлын албаны дарга нарт үүрэг болгосугай.

6. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарт даалгасугай.

